

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

## ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛД ТҮР ХУГАЦААГААР ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дах заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.1 дох заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- 2024 оны 11-р сарын 8-ний өдрөөс эхлэн импортоор орж ирсэн тээврийн хэрэгсэлд Улаанбаатар хотод харьяатай улсын дугаар олгохгүй гэсэн Нийслэлийн засаг даргын захирамж гарч байгаатай холбоотойгоор худалдан авагчид нэмэгдэж, компани харилцагчдадаа уян хатан нөхцлөөр үйлчилгээ үзүүлэх үүднээс Автомашины зээлийн үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулсугай. Өөрчлөлтийг тус тогтоолын Хавсралт 1-ээр баталсугай.
- Зээлийн үйлчилгээний нөхцөлд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 10-р сарын 25-ны өдрөөс 2024 оны 11-р сарын 8-ний өдрийг хүртэл дагаж мөрдсүгэй.
- Зээлийн үйлчилгээний нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ



“Тандэм Инвэст ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2024 оны 10-р сарын 24-ний өдрийн 23 тоот тогтоолоор батлав.

Хавсралт 1



Автомашины зээлийн үйлчилгээний нөхцөл

Зээлийн хэмжээ	150,000,000 төгрөг хүртэл
Зээлийн хүү	2.5 хувь
Зээлийн хугацаа	48 сар хүртэл
Зээлийн урьдчилгаа	15 хувиас дээш
Зээлийн шимтгэл	0.5 хувь
Барьцаа хөрөнгө	Автомашин
Даатгал	Зах зээлийн үнэлгээгээр

# ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

## КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫГ ТҮР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дах заалт, Тандэм Инвэст ББСБ ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2.12.7 дох заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

Компанийн Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэг нь хувийн шалтгаанаар 2024 оны 10-р сарын 28-ний өдрөөс 2024 оны 11-р сарын 1-ний өдрийг дуустал гадаад улсад зорчих болсонтой холбогдуулан компанийн Гүйцэтгэх захирлыг түр орлох ажилтнаар Батхүрэл овогтой Болормааг тус хугацаанд түр томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.ЧИНЗОРИГ

